

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ СҮХБАТЫН ЛХАМЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
Зорилт 1. Салбарын нягтлан бодох бүртгэл, тайлагналын нэгдсэн зохицуулалтыг хангах, хэрэгжилтийг хангана.							
1	Арга хэмжээ 1.1. Төсвийн шууд захирагчийн 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгүүлнэ.	Тайлангийн тоо	2	2	2024 оны Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлан, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу иж бүрэн бэлтгэж, мөн хуулийн 8.9.1-т заасны дагуу 2025 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 03/185 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгүүлсэн. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.1-т заасны дагуу ТЕЗ-ийн харьяа БНҮҮС, ӨНХС-ийн санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/414 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. 2025 оны 03 дугаар сарын 25-нд БНҮҮС-ын аудитын төлөвлөгөөг албажуулан Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. 2025 оны эхний хагас жилийн тайлангийн хуулийн хугацаа болоогүй.	2025.01.01 -06.30	100%
2	Дэд арга хэмжээ – 1.1.1: Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2025 оны эхний хагас жилийн	Хүргүүлсэн баримт бичгийн тоо,	1	1	2024 оны Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу		

	санхүүгийн тайланг гаргаж, Үндэсний аудитын газар, Сангийн яаманд тус тус хүргүүлж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгүүлнэ.	тайлангийн тоо			иж бүрэн бэлтгэж, мөн хуулийн 8.9.1-т заасны дагуу 2025 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 03/185 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлж, ТЭЗ-ын тайланд нэгтгүүлсэн. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.1-т заасны дагуу ТЭЗ-ийн харьяа БНҮҮС, ӨНХС-ийн санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/414 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Тус сан 2024 онд нийт 5.16 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр батлагдсан, 8.01 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 155%-ийн гүйцэтгэлтэй тайлагнасан.	2025.01.01-06.10	100%
3	Дэд арга хэмжээ – 1.1.2: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж, Үндэсний аудитын газарт хүргүүлж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгүүлнэ.	Хүргүүлсэн баримт бичгийн тоо, тайлангийн тоо	1	1	2024 оны Хөрөнгө оруулалтын жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу иж бүрэн бэлтгэж тайлагнасан. 2024 оны хөрөнгө оруулалтын жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлээр 5,28 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн. Үүнд: Барилга байгууламжийн зардалд 7 төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжиж, 5 төсөлд нийт 2.27 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон. Тоног төхөөрөмжийн зардалд 4 төсөл арга хэмжээ шинээр хэрэгжиж, нийт 3.01 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон.	2025.01.01-06.30	100%
4	Арга хэмжээ 1.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргаж, Сангийн яам, Үндэсний аудитын газарт хүргүүлнэ.	Тайлангийн тоо	2	2	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа төсөвт 7, төрийн өмчит 5 байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, холбогдох хоорондын тооцоо, дансны дүн мэдээг тулган баталгаажуулсан. Шууд захирагчдын Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчийн	2025.02.25-05.15	100%

					Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэн, бэлтгэж 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Үндэсний аудитын газарт хүргүүлж, хуулийн хугацаанд аудитаар баталгаажуулан тайлагнасан. 2024 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/958 дугаар албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн.		
5	Дэд арга хэмжээ – 1.2.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн аудитлагдсан тайланг хүлээн авч хянан, баталгаажуулж, санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргаж, Сангийн яам, Үндэсний аудитын газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн баримт бичгийн тоо, тайлангийн тоо	1	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа төсөвт 7, төрийн өмчит 5 байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, холбогдох хоорондын тооцоо, дансны дүн мэдээг тулган баталгаажуулсан. Шууд захирагчдын Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэн, бэлтгэж 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Аудитын хуулийн хугацаанд аудитад хамрагдаж, 2025 оны 02/944 дугаар албан бичгээр УАГ-т асуудлын бүртгэл, тайлбар хүргүүлж, аудитаар баталгаажуулан 2024 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/958 дугаар албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн. Тайлант онд аудитаар 2 төсвийн шууд захирагч түүвэрт хамрагдсан, 5 шууд захирагч хязгаарлалттай, 5 шууд захирагч өөрчлөлтгүй дүгнэлт авсан. Тайлан бэлтгэн боловсруулах, аудитын шалгалтын үед УАГ болон Сангийн яаманд нийт 48 төрлийн судалгаа тайлан мэдээг боловсруулж цаасаар, цахимаар хүргүүлж ажилласан.	2025.02.25-04.25	100%
6	Дэд арга хэмжээ – 1.2.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа	Хүргүүлсэн баримт	1	1	Хуулийн хугацаа болоогүй.		

	байгууллагуудын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хүлээн авч баталгаажуулан, санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргаж, Сангийн яаманд хүргүүлнэ.	бичгийн тоо, тайлангийн тоо				2025.07.01-08.15	
7	Дэд арга хэмжээ – 1.2.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хянаж, хүргүүлнэ.	Тайлангийн тоо	12	6	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд 2025 онд Сайдын багцын урсгал зардлын төсөвт 82.68 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлын төсөвт 35.75 тэрбум төгрөг нийт 118.43 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Сайдын багцын нийт урсгал төсвийн гүйцэтгэл 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 14.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн 2024 оны 12 дугаар сарын болон 2025 оны 1-5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хянаж, баталгаажуулсан.	2025.01.01-06.10	100%
8	Арга хэмжээ – 1.3: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг аудитаар баталгаажуулан, Засгийн газрын нэгтгэсэн тайланд нэгтгүүлнэ.	Тайлангийн тоо	1	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 2024 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланг Монгол Улсын Засгийн газрын нэгтгэсэн тайланд нэгтгүүлэхээр 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/958 дугаар албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийн хооронд Монгол Улсын Засгийн газрын нэгтгэсэн тайлангийн аудитын хуулийн хугацаанд холбогдох тайлбар тодруулга, судалгаа мэдээллийг боловсруулан тухай бүр цахимаар хүргүүлж ажилласан. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2024 оны төсвийн	2025.04.06-06.10	100%

					гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй танилцаж 2024 оны 06 дугаар сарын 09-ны өдөр албан бичгээр хариу хүргүүлсэн. Тайлант онд ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд харьяа төсөвт, төрийн өмчит байгууллагын нийт авлага 27.02 тэрбум төгрөг, богино хугацаат өр төлбөр 35.7 тэрбум төгрөг, 105.6 тэрбум төгрөгийн орлого хүлээн зөвшөөрч, үндсэн үйл ажиллагаа болон нийт /урсгал, хөрөнгийн/ зардалд 96.1 тэрбум төгрөг зарцуулж, нийт балансын хөрөнгө 512.8 тэрбум төгрөг, хуримтлагдсан үр дүн 41.7 тэрбум төгрөгөөр тайлагнасан болно. Мөн ТЕЗ-ын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/1291 дугаар албан бичгээр УАГ-т хүргүүлсэн.		
Зорилт 2. Засгийн газрын тусгай сангийн төлбөр тооцоо, Төрийн сангийн тооцоо, яамны албан хаагчдын цалин, тэтгэмж, хөрөнгийн хөдөлгөөний бүртгэл хийх, хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.							
9	Арга хэмжээ 2.1. Шилэн дансны цахим системд мэдээлэл оруулна.	Байршуулсан мэдээний тоо	42	20	Эхний хагас жилийн байдлаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт 20 мэдээллийг байршуулж, Шилэн дансны тухай хууль тогтоомжид зааснаар ил тод болгон ажилласан.	2025.01.01-06.10	100%
10	Дэд арга хэмжээ – 2.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хөрөнгийн хөдөлгөөний саналыг ТӨБЗГ-т хүргүүлэх, өмч хамгаалах зөвлөлийн хурал зохион байгуулна.	Хүргүүлсэн баримт бичгийн тоо,	3	2	Өмч хамгаалах зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг Зөвлөлийн даргаар батлуулж, эхний хагас жилд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 3 төсөл арга хэмжээний 811.2 сая төгрөгийн хөрөнгийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-д шилжүүлэх саналыг ТӨБЗГ-т 2025 оны 01/83 дугаар албан бичгээр хүргүүлж, ТӨБЗГ-т 2025 оны 01/363 дугаар албан	2025.01.01-06.10	100%

					бичгээр хүргүүлж, 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 35 дугаар “Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай” тогтоол шийдвэрийг гаргуулсан. Мөн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн балансад бүртгэлтэй Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт байгаа 1992 оны барилгыг орон нутгийн өмчид Дархан-Уул аймгийн ЗДТГ-т шилжүүлэх саналыг холбогдох журмын дагуу хянан ТӨБЗГ-т 2025 оны 01/363 дугаар албан бичгээр хүргүүлж, 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 105 дугаар “Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай” тогтоол шийдвэр гарч Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлан бүртгэлд бүртгэсэн.		
Зорилт 3. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.							
11	Арга хэмжээ 3.1. Нэгжид хуваарилагдсан баримт бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35.4 дүгээр заалтын хэрэгжилтийг хангах, хяналт тавих	Баримт бичгийн тоо	0%	50%	Ажлыг гүйцэтгэлийг улирал, сар, долоо хоног тутам тайлагнасан. Мөн ЗГ-ын хуралдаанаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн яамны холбогдох заалтад Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн хамаарах дүн мэдээ, тайлбарыг тухай бүр өгч, цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 48 төрлийн судалгаа, мэдээллийг боловсруулж цахимаар болон цаасаар СЯ, ҮАГ, ТӨБЗГ-т хүргүүлсэн. Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартыг мөрдөж, 7 боть архивын нэгжийн материалыг бүрдүүлж, бэлтгэсэн.	2025.01.01-06.10	100%
Зорилт 4. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг ур чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлнэ.							
12	Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалт, surgalt.gov.mn цахим сургалт, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв	Сургалтад хамрагдсан тоо	10	5	Сангийн яамнаас зохион байгуулсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалт, үр ашиг сэдэвт танхимын сургалтад 06 дугаар сарын 5-ны өдөр хамрагдсан.	2025.01.01-06.10	

	байгууллагын мэргэшлийн сургалтад тус тус хамрагдах				-Худалдан авах ажиллагааны АЗ сургалтад хамрагдсан. -Дэлхийн банкны төслийн нэгжээс зохион байгуулсан Төсвийн төлөвлөлт, НҮБ хүүхдийн сангаас зохион байгуулсан “Санхүүжилтийн журмын шинэчлэл” сургалтад 5 дугаар сард хамрагдсан. -Surgalt.gov.mn цахим сургалт Дижитал мэдээлэл, Мэдээллийн аюулгүй байдал сэдэвт сургалтад тус тус хамрагдсан.		
13	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон Авилгийн эсрэг хууль тогтоомжийг мөрдөх, хэрэгжилтийг хангах.	Мэдүүлгийн тоо	0	1	Хуулийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлгээ бөглөж, баталгаажуулсан.	2025.01.01-02.10	

2. Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт


Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	Үүрэг даалгавар 1. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө төвлөрүүлэлт, тайлан нийлэх асуудалд анхаарч ажиллах.	Тоо, дүн	0%	2.0 тэрбум төгрөг	БНҮҮС-ийн хөрөнгө төвлөрүүлэлттэй холбоотой аж ахуй нэгж, компанитай тооцоо нийлж, баталгаажуулсан дүнг хянах, 2025 оны 06 дугаар сарын байдлаар 2.2 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө төвлөрч Төсвийн тухай хуулиар батлагдсан төлөвлөгөөг 130% биелүүлсэн. 2008-2020 он хүртэлх олон жилийн насжилттай авлагын тооцоотой ААН компаниудын баримт маягтыг АЕГ-аас шүүж бэлтгэсэн. хүргүүлж, хамтран ажиллаж байна.	2025.01.01-04.30	100%
2	Үүрэг даалгавар 2. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, УТХО-ын бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй хөрөнгийг шилжүүлэх, ажил үйлчилгээг хүлээн	Тоо, дүн	0%	4.0 тэрбум төгрөг	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан болон Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй хөрөнгийг шилжүүлэх, ажил үйлчилгээг хүлээн зөвшөөрөх ажлын хүрээнд дараах ажлыг хийсэн. Үүнд:	2025.01.01-06.10	100%

	зөвшөөрөх ажлыг зохион байгуулах, арга хэмжээ авч ажиллах.				-2008-2022 онд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болсон хөрөнгө, ажил үйлчилгээг төсөл тус бүрээр ангилж зардлаар хүлээн зөвшөөрөх төслүүдийг эрэмбэлж ангилсан. Нийт 10.3 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ. -2019-2022 онд хэрэгжиж дууссан УТХО Хур төслийн 27 багц ажлын 21.2 тэрбум төгрөгийн ажил, их засварын өртөг байршлыг тус бүрээр нь ангилж, хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэж, Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр танилцуулга боловсруулсан.		
3	Үүрэг даалгавар 3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн аудит /2022-2024/ мэдээлэл хүргүүлж, аудитын хугацаанд чиг үүргийн дагуу ажиллах.	Мэдээлэл судалгаан ы тоо, дүн	0%	5	Үндэсний аудитын газраас 2025 оны 04-05 дугаар сард “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн аудит /2022-2024/” хууль тогтоомжийн хэрэгжилтийн нийцлийн аудит хийгдсэн. Аудитаар төсөвт болон УТҮГ-д түүврээр судалгаа мэдээлэл авч аудитад хамрагдсан. Мэдээлэл ХХК, Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ, Монгол шуудан ХК, Монголын цахилгаан холбоо ХК-д хуваарийн дагуу аудитын баг ажилласан. Аудитын явцад 9 төрлийн судалгаа мэдээллийг ТЕЗ-аар нэгтгэн хүргүүлж, тайлбар өгч ажилласан.	2025.01.01-06.10	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Төрийн захиргааны удирдлагын газрын
Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтсийн
Төсвийн ерөнхийлөн захирагчийн
нэгтгэсэн санхүүгийн тайлан хариуцсан
шинжээч бөгөөд ерөнхий нягтлан бодогч

С.Лхам / /



2025 оны 06 дугаар сарын 09,